

ТАНИЛЦУУЛГА

Маягтын загвар батлах тухай

Иргэний хуулийн 318 -326 дугаар зүйл, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15, 22 дугаар зүйл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 12 дугаар зүйлд тус тус түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалт болон эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх үндэслэл, шаардагдах нотлох баримтын талаар хуульчилж өгсөн байдаг.

Иргэний хуулийн 318 дугаар зүйлийн 318.3-т “Түрээсийн гэрээг бичгээр байгуулах бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн газарт бүртгүүлнэ”, 318.4-д “Энэ хуулийн 318.3-т заасан шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.” гэж заасан бөгөөд сүүлийн жилүүдэд иргэн, хуулийн этгээдийн зүгээс үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх нь өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар:

Үйлчилгээий төрөл	Улсын хэмжээнд	Нийслэлийн хэмжээнд	Сүхбаатар дүүрэг
Түрээсийн гэрээ	2840	2630	980
Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлт	631	620	599
Түрээсийн гэрээ дуусгавар болох	1134	966	310

Сүүлийн 1 жилийн байдлаар:

Үйлчилгээий төрөл	Улсын хэмжээнд	Нийслэлийн хэмжээнд	Сүхбаатар дүүрэг
Түрээсийн гэрээ	660	602	179
Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлт	230	230	229
Түрээсийн гэрээ дуусгавар болох	309	267	85

Сүүлийн нэг жилийн байдлаар Нийслэлийн Баянгол дүүрэгт түрээсийн гэрээ 83, дуусгавар болгох 28, Баянзүрх дүүрэгт түрээсийн гэрээ 135, дуусгавар болгох 56, Сонгинохайрхан дүүрэгт түрээсийн гэрээ 40, дуусгавар болгох 15, Хан- Уул дүүрэгт түрээсийн гэрээ 119, дуусгавар болгох 45, Чингэлтэй дүүрэгт түрээсийн гэрээ 36, дуусгавар болгох 37 бүртгэлийг тус тус бүртгэсэн байна.

Тухайлбал:

–Эрхийн улсын бүртгэлийн Ү-2203020150 дугаартай “Шангри Ла Улаанбаатар” ХХК-ийн өмчлөлийн /Central tower/ барилгын эрхийн улсын бүртгэлд 1082 түрээсийн гэрээ болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэл бүртгэсэн хувийн хэрэг нь архивын **108 боть** /цэнхэр хайрцаг гэж ойлгох/ буюу 280 хувийн хэрэг байршуулах талбай;

–Эрхийн улсын бүртгэлийн Ү-2203034940 дугаартай “Шангри Ла Улаанбаатар Хотел” ХХК-ийн өмчлөлийн барилгын эрхийн улсын бүртгэлд 286 түрээсийн гэрээ болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэл бүртгэсэн хувийн хэрэг нь архивын **34 боть** буюу 136 хувийн хэрэг байршуулах талбай;

–Эрхийн улсын бүртгэлийн Ү-2203035983 дугаартай “Шангри Ла Улаанбаатар Хотел” ХХК-ийн өмчлөлийн /Central tower/ барилгын эрхийн улсын бүртгэлд 177 түрээсийн гэрээ болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэл бүртгэсэн хувийн хэрэг нь архивын **17 боть** буюу 85 хувийн хэрэг байршуулах талбайд тус тус байршин Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн архивт хадгалагдаж байна.

Дээрх түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхдээ мэдүүлэгт дунджаар 97-100 хуудас бүхий 3 хувь түрээсийн гэрээ болон холбогдох бусад нотлох баримтыг хавсаргаж ирүүлдэг бөгөөд түрээсийн гэрээний нэг хувь болон бусад шаардлагатай план зураг гэх мэт нотлох баримт болох 30-40 хуудас нотлох баримтыг цахим мэдээллийн санд скандердаж оруулан, цаасан нотлох баримтыг архивлан авдаг.

“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой үл хөдлөх эд хөрөнгийн бусад эрхийг бүртгэх маягад дараах мэдээллийг тусгана:”, 22 дугаар зүйлийн 22.1-д “Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн эрхийг түрээслэгч, түрээслүүлэгчийн аль нэг талын гаргасан мэдүүлгийг үндэслэн энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан журмын дагуу бүртгэнэ.” гэж тус тус заасан.

Иймд үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн бүртгэлийг түрээсийн гэрээний эх хувийг шаардалгүйгээр хуульд заасан мэдээллийг тусгасан маягыг үндэслэн бүртгэх боломжтой байна.

Түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгэх тухай маягыг баталснаар иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, улсын бүртгэлийн цахим сангийн ачааллыг багасгах, эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт авах цаасан баримтыг цөөлөх, архивын өрөөний зай талбайг хэмнэх чухал ач холбогдолтой байх тул “Түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт”, “Түрээсийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт”-ийн маягтын загваруудыг тус тус шинээр боловсруулан танилцуулж байна.

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

ЭУБ-14 маягт

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭГ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ

Ерөнхий мэдээлэл							
Хүсэлт гаргасан он, сар, өдөр			... оны ... сарын ... -ны өдөр				
	Гэрээ байгуулсан он, сар, өдөр		... оны ... сарын ... -ны өдөр				
	Гэрээний дугаар					
	Гэрээ байгуулсан газар					
Гэрээнд оролцогч талууд	Түрээслэгч		Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар: Хаяг: Хуулийн этгээд бол оноосон нэр, хэлбэр: Регистрийн дугаар: Хаяг: Төлөөлөх эрх бүхий этгээдийн Албан тушаал: Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар:				
	Түрээслүүлэгч		Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар: Хаяг: Хуулийн этгээд бол оноосон нэр, хэлбэр: Регистрийн дугаар: Хаяг: Төлөөлөх эрх бүхий этгээдийн Албан тушаал: Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар:				
Түрээслэж буй хөрөнгийн мэдээлэл							
№	Эрхийн УБД	Байршлын хаяг	Өмчлөгчийн овог, нэр	Хэмжээ	Зориулалт	Өмчлөх эрхийн гэрчилгээн ий дугаар	Бусад
1.							
Өмчлөгчийн дэлгэрэнгүй мэдээлэл:							
Иргэн бол:							
№	Ургийн овог	Эцэг /эх/-ийн нэр	Өөрийн нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар		
1.							
2.							
Хуулийн этгээд бол:							
№	Оноосон нэр	Хэлбэр	Регистрийн дугаар	Утасны дугаар			
1.							
2.							

Гэрээний мэдээлэл	Түрээсийн гэрээний хугацаа /сараар/		
	Түрээсийн гэрээний үнэ		
	Түрээслэж буй талбайн хэмжээ		
	Түрээслэж буй талбайн зураг төслийг хавсаргасан эсэх		<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <i>/талбай хэсэгчлэн түрээслэж буй тохиолдолд зураг төслийг заавал хавсаргана /</i>	
	Түрээсийн зориулалт		
	Түрээсийн төлбөр төлөх нөхцөл		
	Түрээсийн гэрээ цуцлах нөхцөл		
	Дамжуулан түрээслэх эсэх		<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	
	Нотариатаар гэрчлэгдэх эсэх		<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	
	Гэрээнд төлөөллөөр буюу итгэмжлэлээр оролцсон эсэх		<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	
Нэмэлт мэдээлэл /шаардлагатай бусад мэдээлэл/			
ХҮСЭЛТ ГАРГАСАН		Нэр, албан тушаал	Гарын үсэг	Тамга
түрээслэгч	1.			
	2.			
түрээслүүлэгч	1.			
	2.			
ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭСЭН	Улсын бүртгэгчийн нэр		Гарын үсэг/тэмдэг	Бүртгэсэн огноо

ЭУБ-15 маягт

**ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД
БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ**

Ерөнхий мэдээлэл				
Хүсэлт гаргасан он, сар, өдөр		... оны ... сарын ... -ны өдөр		
Гэрээнд оролцогч талууд	Түрээслэгч	Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар: Хаяг: Хуулийн этгээд бол оноосон нэр, хэлбэр:..... Регистрийн дугаар: Хаяг: Төлөөлөх эрх бүхий этгээдийн Албан тушаал: Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар:		
	Түрээслүүлэгч	Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр: Регистрийн дугаар: Хаяг: Хуулийн этгээд бол оноосон нэр, хэлбэр Регистрийн дугаар: Хаяг: Төлөөлөх эрх бүхий этгээдийн Албан тушаал: Эцэг /эх/-ийн нэр: Өөрийн нэр:		
Үндсэн гэрээний мэдээлэл	Гэрээ байгуулсан он, сар, өдөр	... оны ... сарын ... -ны өдөр		
	Гэрээний дугаар		
Нэмэлт өөрчлөлт оруулсан гэрээний мэдээлэл	Гэрээ байгуулсан он, сар, өдөр	... оны ... сарын ... -ны өдөр		
	Гэрээний дугаар		
Нэмэлт өөрчлөлтийн агуулга				
/Үндсэн гэрээний өөрчлөлт орсон зүйл, заалт тус бүрээр дурдах/				
ХҮСЭЛТ ГАРГАСАН		Нэр, албан тушаал	Гарын үсэг	Тамга
Түрээслэгч	1.			
	2.			
Түрээслүүлэгч	1.			
	2.			
ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭСЭН	Улсын бүртгэгчийн нэр		Гарын үсэг/тэмдэг	Бүртгэсэн огноо

ТАНИЛЦУУЛГА

Маягтын загварт өөрчлөлт оруулах тухай

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх мэдүүлэг, маягтын загварыг УБЕГ-ын даргын 2021.07.06-ны өдрийн А/429 дугаар тушаал, 2022.05.23-ны өдрийн А/427 дугаартай тушаалуудаар тус тус шинэчлэн батлуулан өдөр тутмын бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэглэж байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай бол баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэсэн тухай Хорооны шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлд барьцааны тухай тусгай тэмдэглэл хийнэ.”, 14.7 дэх хэсэгт “Энэ хуулийн 14.4-т заасан тэмдэглэлийн агуулга, тэмдэглэл хийх журмыг Хороо болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тус тус заасны дагуу Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2013.07.25-ны өдрийн А/167/203 дугаар тушаалын хавсралтаар “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам” батлагдсан бөгөөд 2014 оны 01 дүгээр сараас эхлэн эрхийн улсын бүртгэлд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэж эхэлсэн.

МИК ОССК ХХК-аас ирүүлсэн 2023.03.27-ны өдрийн 23/06-287 дугаартай Хамтран ажиллах уулзалт зохион байгуулах тухай албан бичгийн хүрээнд 2023.04.03-ны өдөр уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уг уулзалтаар Барьцааны гэрээний дуусгавар болгох бүртгэл болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгүүлэхдээ Цахимаар барьцааны гэрээ бүртгүүлэх системийг нэвтрүүлж хэрэглэнд оруулахаар ярилцсан. /Мөн цахимаар хүсэлт ирүүлэхдээ цахим гарын үсгийг ашиглаж байхаар эхний байдлаар тохирсон/

Мэдээллийн технологийн газраас системийн хөгжүүлэлттэй холбоотой мэдээллийг хүргүүлж ажилласан бөгөөд тус газрын зүгээс ЭУБ-10 маягтад өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн. Учир нь дээрх тусгай тэмдэглэлийг хийхийн тулд “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам”-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр, уг хороонд бүртгүүлсэн хөрөнгийн багц дахь үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, хөрөнгийн тусгай зориулалттай компанид шилжүүлсэн гэрээ зэргийг хувийн хэрэгт хавсарган авдаг.

Дээрх нотлох баримтуудаас зөвхөн бүртгүүлэхийг хүссэн ТЗК-ийн хүсэлт эх хувиар ирээд бусад нь бүгд хуулбар хувиар ирдэг бөгөөд хөрөнгийн тусгай зориулалттай компанид шилжүүлсэн гэрээг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан маягтаар орлуулах боломжтой гэж үзэн маягтын загварыг шинэчлэн боловсруулан танилцуулж байна.

Сүүлийн 1 жилийн хугацаанд буюу 2022.05.01-2023.05.01-ний өдрийн байдлаар эрхийн улсын бүртгэлд 2365 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэсэн байна. /ePRS системийн албан бичиг цэснээс “МИК” түлхүүр үгээр шүүлт хийсэн/

Хөрөнгийн тусгай зориулалттай компанид шилжүүлсэн гэрээ нь ойролцоогоор 40-60 хуудас, нэг ТЗК нь ойролцоогоор 8-13 арилжааны банктай гэрээ байгуулдаг бөгөөд нийт үл хөдлөх эд хөрөнгө нь ойролцоогоор 500-3000 гаруй байдаг.

Жишээлбэл: Хамгийн сүүлийн байдлаар ХУД-ийн УБХ-т гаргасан нэг хүсэлт дээр жишээ авахад: 2023.04.26-ны өдөр МИК актив 32 ТЗК-аас багц бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн бөгөөд хавсралтаар нийт 9 банктай тус бүр байгуулсан гэрээ, багц дахь нийт 1998 үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалттай. Үүнийг системд боловсруулж тусгай тэмдэглэл хийхэд 9 банкны хөрөнгийн жагсаалт болон гэрээний эх хувийг 9 хувийн хэрэгт сканнердаж оруулахад нэг хувийн хэрэгт ойролцоогоор 51 хуудас нотлох баримт, нийт 459 зурган файл, үлдсэн 1989 хувийн хэрэгт 3 хуудас зурган файл бүгд нийлээд 6426 зурган файл системд орж байгаа юм. Энийг ЭУБ-10 маягтыг ашиглан бүртгэвэл нэг хувийн хэрэг ойролцоогоор 2 хуудас, нийт 1998 үл хөдлөх эд хөрөнгийн хувийн хэрэгт нийт 3996 зурган файл систем орох бөгөөд системд орох зурган файл 62%-аар багасч системд өгөх ачаалал тэр хэмжээгээр буурна гэж үзэж байна.

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

-----000-----

**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГИЙН
БАГЦЫГ ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ ХИЙЖ БҮРТГЭХ МАЯГТ**

Хүсэлт гаргасан он, сар, өдөр:

Эрх шилжүүлэгчийн нэр, регистрийн дугаар:

Эрх хүлээн авагчийн нэр, регистрийн дугаар:

Д/д	Агуулга	Тайлбар
1.	Гэрээний огноо, дугаар	
2.	Баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн огноо, дугаар	
3.	Нотлох баримтын эх хувь хадгалагдаж байгаа хувийн хэргийн эрхийн улсын бүртгэлийн дугаар	
4.	Хөрөнгийн багц дахь үл хөдлөх эд хөрөнгийн тоо	
5.	Бүртгэлийн нэгжийн нэр	
6.	Улсын бүртгэгчийн	Нэр
		Бүртгэсэн он, сар, өдөр
		Гарын үсэг
	Хувийн дугаар бүхий тэмдэг дарна.	

ЭУБ-10 маягт

ТӨСӨЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/429 дүгээр тушаалаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх маягт /ЭУБ-10 маягт/"-д өөрчлөлт оруулсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны . . . дугаар тушаалын хавсралт

**ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГИЙН
БАГЦЫГ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ**

Хүсэлт гаргасан он, сар, өдөр.....

Эрх шилжүүлэгчийн нэр, регистрийн дугаар, хэлбэр

Эрх хүлээн авагчийн нэр, регистрийн дугаар, хэлбэр.....

Д/Д	Агуулга	Тайлбар
1	Гэрээний нэр	
2	Гэрээний он, сар, өдөр, дугаар	
3	Баталгаат үнэт цаасыг бүртгэсэн тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийн он, сар, өдөр, дугаар	
4	Хороонд бүртгүүлсэн хөрөнгийн багц дахь үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтад дурдсан үл хөдлөх эд хөрөнгийн тоо	
5	Бусад мэдээлэл	
6	Бүртгэлийн нэгж	

Бүртгүүлэх хүсэлт гаргасан:

Бүртгэсэн:

Эрх бүхий албан тушаалтан

Улсын /ахлах/ бүртгэгч

...../...../

...../...../

Гарын үсэг, тэмдэг Нэр, он, сар, өдөр

Гарын үсэг, тэмдэг

Нэр, он, сар, өдөр

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Тушаалд өөрчлөлт оруулж, маягтын загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.10 дахь заалт, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх мэдүүлэг, маягтын загварыг шинэчлэн батлах тухай” А/429 дүгээр тушаалын 10 дугаар хавсралтаар баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх маягт /ЭУБ-10 маягт/-д өөрчлөлт оруулсугай.

2.”Түрээсийн гэрээг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-14 маягт/”, “Түрээсийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт /ЭУБ-15 маягт/-ийн загварыг хавсралтаар тус тус баталсугай.

3.Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар /Б.Ариунболд/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

ХЯНАСАН:

ЭХЭУБГ-ЫН ДАРГА

Б.АРИУНБОЛД

ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ХЭРЛЭНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ЭХЭУБГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.СУВД-ЭРДЭНЭ

УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Л.ГАНСҮХ